



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/13-НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn</p> <p>Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhuyach@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Наранцэцэг Утас: 70362442 Цахим хаяг: Narantsetsegb@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9-10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12-13
3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4. Материаллаг байдал.....	14
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.5.1 Мөнгөн хөрөнгө.....	15
3.5.2 Авлага	15
3.5.3 Бараа материал	16
3.5.4 Үндсэн хөрөнгө	17
3.5.5 Өр төлбөр	18
3.5.6 Засгийн газрын хувь оролцоо.....	19
3.5.7 Орлогын данс	19
3.5.8 Зарлагын данс.....	19
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	20-21
3.6.1 Төсвийн төлөвлөлт.....	22
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	23
3.6.3 Нэмэлт санхүүжилт	24
3.7. Асуудлын онцлох хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	25
3.8. Аудитын гол асуудал	26
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	26
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	26
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	27
3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	27
3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	28
4. Аудитын илрүүлэлт.....	28
4.1 Залруулсан алдаа.....	28
4.2 Төлбөрийн акт	29
4.3 Албан шаардлага	30
4.4 Зөвлөмж.....	31-34
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	35-37

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СХС	Сум хөгжүүлэх сан
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ХААГ	Хөдөө аж ахуйн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.25 № СЭА-2022/13-НА-СТА-ТТЗ

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Түшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Түшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	686,970.8	888,742.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	267,973.3	426,120.7
33	АВЛАГА	202,835.8	198,762.4
35	БАРАА МАТЕРИАЛ	216,161.7	263,859.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,195,951.0	4,606,940.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,195,951.0	4,606,940.2
39200	Биет хөрөнгө	4,074,331.3	4,486,733.0
39300	Биет бус хөрөнгө	121,619.7	120,207.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,882,921.8	5,495,683.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,650.9	667.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,650.9	667.1
41300	Өглөг	5,650.9	667.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,877,271.0	5,495,016.0
51	Засгийн газрын хувь оролцоо	4,877,271.0	5,495,016.0
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,873,329.3	1,873,329.3
51200	Хуримтлагдсан үр дүн	1,826,309.7	2,444,054.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,177,631.9	1,177,631.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,882,921.8	5,495,683.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,580,626.7	3,277,996.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	164,934.2	352,928.4
110	Орлогын албан татвар	34,811.3	33,191.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	34,811.3	33,191.4
113	Хөрөнгийн албан татвар	2,224.0	46,364.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	127,898.9	273,373.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,890,575.2	706,766.8
120	Нийтлэг татварын бус орлого	1,890,575.2	706,766.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,525,117.4	2,218,301.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,751,519.0	2,455,348.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,751,519.0	2,455,348.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,033,895.9	2,351,159.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,297,557.8	1,369,097.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	168,077.2	179,672.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	151,949.0	222,345.6
2104	Хангамж, бараа материалын зардал	89,765.9	63,294.7
2105	Нормативт зардал	103,109.4	129,830.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,305.7	23,286.3
2107	Томилолт, зочны зардал	3,748.7	3,341.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,043.2	15,519.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	199,338.8	344,770.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	717,623.2	104,189.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,829,107.7	822,648.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	100,440.2	204,498.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,728,667.5	618,150.1

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,896,604.1	2,644,206.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	164,934.2	352,928.4
110	Орлогын албан татвар	34,811.3	33,191.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	34,811.3	33,191.4
113	Хөрөнгийн албан татвар	2,224.0	46,364.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	127,898.9	273,373.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,974.7	8,415.3
1181	Газрын төлбөр	12,957.4	40.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	112,966.8	264,917.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	179,888.8	78,110.2
120	Нийтлэг татварын бус орлого	179,888.8	78,110.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,551,781.2	2,213,167.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,567,118.6	2,175,400.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,567,118.6	2,175,400.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,817,319.2	2,069,109.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,299,160.6	1,368,210.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	166,353.1	179,877.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	151,949.0	222,419.4
2104	Хангамж, бараа материалын зардал	46,876.4	46,605.8
2105	Нормативт зардал	85,220.6	150,826.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,842.3	23,763.0
2107	Томилолт, зочны зардал	3,748.7	3,341.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,912.8	15,739.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,255.8	58,325.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	749,799.4	106,291.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	329,485.5	468,806.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	167,060.2	253,658.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	167,060.2	253,658.8
2200	Дотоод эх үүсвэрээр	167,060.2	253,658.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-167,060.2	-253,658.8
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-57,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	57,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	162,425.3	158,147.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	105,548.0	267,973.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	267,973.3	426,120.7

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,148,603.40	0	3,148,603.40
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,148,603.40	0	3,148,603.40
3	Тайлант үеийн үр дүн	1,728,667.50	0	1,728,667.50
4	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,877,271.00	0	4,877,271.00
5	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,877,271.00	0	4,877,271.00
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	8,345.00	0	8,345.00
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,885,616.00	0	4,885,616.00
8	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	31,467.40	0	31,467.40
9	Тайлант үеийн үр дүн	571,208.80	0	571,208.80
10	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,488,292.10	0	5,488,292.10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
II	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,468,549.70	2,302,878.83	165,670.87	93.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,153,505.60	2,040,130.57	113,375.03	94.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,099,595.20	1,991,675.81	107,919.39	94.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,404,054.00	1,355,558.76	48,495.24	96.5
210101	Үндсэн цалин	1,049,922.50	775,058.53	274,863.97	73.8
210102	Нэмэгдэл	253,304.50	482,381.06	-229,076.56	190.4
210104	Урамшуулал	67,055.40	69,686.83	-2,631.43	103.9
210105	Гэрээт ажлын хөлс	33,771.60	28,432.34	5,339.26	84.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	188,822.80	178,162.22	10,660.58	94.4
210201	Тэтгэврийн даатгал	132,626.10	124,065.22	8,560.88	93.5
210202	Тэтгэмжийн даатгал	14,049.10	13,458.46	590.64	95.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,239.50	10,619.61	619.89	94.5
210204	Ажилгүйдлийн даатгал	2,809.70	4,403.58	-1,593.88	156.7
210205	Эрүүл мэндийн даатгал	28,098.40	25,615.35	2,483.05	91.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	239,609.00	222,419.38	17,189.62	92.8
210301	Гэрэл, цахилгаан	22,965.40	22,557.11	408.29	98.2
210302	Түлш, халаалт	215,448.70	199,146.57	16,302.13	92.4
210303	Цэвэр, бохир ус	1,194.90	715.70	479.20	59.9
2104	Хангамж, бараа материалын зардал	42,585.30	41,534.00	1,051.30	97.5
210401	Бичиг хэрэг	4,427.50	4,434.20	-6.70	100.2
210402	Тээвэр, шатахуун	24,696.00	24,472.30	223.70	99.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,530.40	4,597.00	-66.60	101.5
210404	Ном, хэвлэл	286.00	285.10	0.90	99.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,450.60	3,450.60	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,194.80	4,294.80	900.00	82.7
2105	Нормативт зардал	73,437.10	61,529.85	11,907.25	83.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,874.40	11,874.40	0.00	100.0
210502	Хоол, хүнс	53,778.70	41,871.45	11,907.25	77.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,784.00	7,784.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	68,374.00	66,083.02	2,290.98	96.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	44,352.50	44,352.50	0.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	566.20	566.20	0.00	100.0
210604	Урсгал засвар	23,455.30	21,164.32	2,290.98	90.2
2107	Томилолт, зочны зардал	3,333.10	3,161.90	171.20	94.9
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00	0.00	
210702	Дотоод албан томилолт	3,333.10	3,161.90	171.20	94.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,262.90	19,201.17	2,061.73	90.3

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,439.10	16,348.27	90.83	99.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,148.60	1,512.00	1,636.60	48.0
210803	Даатгалын үйлчилгээ	241.30	0.00	241.30	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,103.50	1,103.50	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	93.00	0.00	93.00	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	200.00	200.00	0.00	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	37.40	37.40	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,117.00	44,025.52	14,091.48	75.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,788.50	38,697.10	14,091.40	73.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,328.50	5,328.42	0.08	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,910.40	48,454.76	5,455.64	89.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,910.40	48,454.76	5,455.64	89.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,498.30	19,996.91	4,501.39	81.6
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,704.50	23,704.50	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,707.60	4,753.35	954.25	83.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	241,504.10	205,748.26	35,755.84	85.2
220001	Барилга байгууламж	236,504.10	205,748.26	30,755.84	87.0
223001	Бусад хөрөнгө	5,000.00	0.00	5,000.00	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	73,540.00	57,000.00	16,540.00	77.5
230001	Эргэж төлөгдөх зээл	73,540.00	57,000.00	16,540.00	77.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,468,549.70	2,199,706.24	268,843.46	89.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,327,900.10	1,294,514.44	33,385.66	97.5
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,327,900.10	1,294,514.44	33,385.66	97.5
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	893,816.40	825,870.69	67,945.71	92.4
320001	Орон нутгийн төсвөөс	804,181.60	736,235.89	67,945.71	91.6
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	89,634.80	89,634.80	0.00	100.0
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	20,263.90	9,279.72	10,984.18	45.8
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	20,263.90	9,279.72	10,984.18	45.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	226,569.30	70,041.39	156,527.91	30.9
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	74,700.00	70,041.39	4,658.61	93.8
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	151,869.30	0.00	151,869.30	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	190,530.98	-190,530.98	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	87,358.39	-87,358.39	

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	149,794.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	149,794.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	125,343.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,651.48
210101	Үндсэн цалин	2,033.39
210102	Нэмэгдэл	10,618.09
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,715.33
210201	Тэтгэврийн даатгал	1,715.33
2104	Хангамж, бараа материалын зардал	5,317.31
210401	Бичиг хэрэг	1,185.40
210402	Тээвэр, шатахуун	3,195.35
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	118.87
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	795.20
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22.50
2105	Нормативт зардал	89,296.46
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	89,296.46
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	350.00
210604	Урсгал засвар	350.00
2107	Томилолт, зочны зардал	180.00
210702	Дотоод албан томилолт	180.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,533.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,353.10
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,450.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,600.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,850.80
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,850.80
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	149,794.48
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	149,794.48
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	14,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,606.15
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	65,520.70
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	46,367.63

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Түшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч /Цаашид Түшиг сумын ТТЗ гэх/-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон төлбөрийн цахим баримттай холбоотойгоор өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Түшиг сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 1/34 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Түшиг сумын ТТЗ нь үйл ажиллагааны эрхэм зорилгыг *“Ирээдүй нь гэрэлтэй, Иргэд нь жаргалтай сум болохын төлөө”* гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-

соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,

- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоолоор төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах шаардлагыг төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан,
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах “Босго үнэ шинэчлэн батлах тухай” журмыг баталсан,
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдөгдөж эхэлсэн,
- Аймгийн ТЭЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан,
- Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” шинэчлэн батлагдсан,

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” шинэчлэн батлагдсан,
- Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах хэсэгт 2021 оны 7 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан,
- Засгийн газрын 2020 оны 184 дүгээр тогтоолоор “Ойгоос бэлтгэж ашиглах 1 шоо-метр хэрэглээний мод, түлээнд ногдуулах төлбөрийн хэмжээг шинэчлэн баталсан” гэх мэт.
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд ТТЗ-ийн дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж дүгнэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Түшиг сумын ТТЗ-ын харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд 2021 онд аймгийн ТЭЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түшиг сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 2,462,072.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 24,620.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 17,234.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 267,973.3 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 426,120.7 мянган төгрөг болж, 158,147.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	267,973.3	426,120.7	158,147.4
Дүн	267,973.3	426,120.7	158,147.4

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тайлагнагдсан 338,372.2 мянган төгрөг ОНХО-ын дансанд, 39,560.6 мянган төгрөг ОНХС-ийн дансанд, 46,878.4 мянган төгрөг СХС-ийн дансанд, 390.0 мянган төгрөг барьцаа хөрөнгийн дансанд, 919.5 мянган төгрөг ЭМТ-ийн дансанд тус тус байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 202,835.8 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 198,762.4 мянган төгрөг болж, 4,073.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Татаас, санхүүжилтийн авлага	5,133.8	11,595.5	6,461.7
Зээлийн хүүгийн авлага	3,358.2	2,195.1	(1,163.1)
Хувь хүмүүсээс авах авлага	2,464.4	2,464.4	-
Байгууллагаас авах авлага	11,449.9	12,311.3	861.4
Зээлийн авлага	180,429.5	170,196.0	(10,233.5)
Дүн	202,835.8	198,762.3	(4,073.5)

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 91,577.3 мянган төгрөгийн авлага байна. Үүнд:

- ОНХО-ын дансанд бүртгэлтэй 2010-2011 онд 5 иргэнд олгосон итгэлийн зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл 2,464.4 мянган төгрөг /тооцоо нийлсэн акт байхгүй, эзэн тодорхойгүй/,
- ОНХС-ийн дансанд 2013 онд тус сангийн эх үүсвэрээр хийгдэхээр төлөвлөгдсөн “Цэцэрлэгийн барилгын засвар”-ын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Баатар булаг” ХХК-д 6,000.0 мянган төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн боловч ажил огт хийгдээгүйгээс үүссэн /шүүхэд шилжүүлсэн боловч эцэслэж шийдвэрлэгдээгүй/,

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

- СХС-ийн дансанд 2011-2018 онуудад олгосон эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн авлагын нийт 83,112.9 мянган төгрөг зэрэг авлагууд бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

ИТХ:

- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 108.3 мянган төгрөгийн НДШ-ийн авлага үүсгэсэн.

ЗДТГ:

- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 398.9 мянган төгрөгийн НДШ-ийн авлага үүсгэсэн.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 216,161.7 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 263,859.7 мянган төгрөг болж, 47,698.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	15,713.7	28,093.1	12,379.4
Эм боох материал	9,861.8	8,765.7	(1,096.1)
Бэлэн бүтээгдэхүүн	28.0	2,054.6	2,026.6
Түлш шатах тослох материал	1,315.2	937.3	(377.9)
Аж ахуйн материал	161,868.9	164,025.9	2,157.0
Хүнсний материал	868.0	6,205.0	5,337.0
Бусад хангамжийн материал	26,276.1	53,548.1	27,272.0
Мал амьтад	230.0	230.0	-
Дүн	216,161.7	263,859.7	47,698.0

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Материалын дансны үлдэгдэл 47,698.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 497,819.7 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, дээд шатны байгууллагаас 31,369.1 мянган төгрөгийг шилжүүлж авсан, хандив, тусламжаар 34,026.2 мянган төгрөгийг үнэ төлбөргүй хүлээн авсан зэрэг нийт 563,215.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, 289,411.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан, ОНХС-ийн эх үүсвэрээр бэлтгэсэн 209,265.8 мянган төгрөгийг ашиглагч байгууллагад шилжүүлж, 16,840.1 мянган төгрөгийн бараа материалыг акталж, данснаас хассанаас шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

ИТХ:

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

- Аж ахуйн материал дансанд 1,115.0 мянган төгрөгийн материал бүртгэлтэй боловч тооллогоор баталгаажуулаагүй, бараа материал бодитой оршин байхгүй байна.

ЗДТГ:

- Тайлант онд 45,507.8 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

ЭМТ:

- Албан хаагчдад тавьж олгосон 3,624.6 мянган төгрөгийн нормын хувцас, хэрэглэлийг тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй.
- Тайлант онд 38,265.3 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

Соёлын төв:

- Тайлант онд 16,462.4 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

ЕБС:

- Тайлант онд 10,674.8 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

Цэцэрлэг:

- Тайлант онд 2,747.3 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл /анхны өртгөөр/ 5,132,616.9 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 5,417,861.5 мянган төгрөг болж, 285,244.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	3,219,991.2	3,348,672.2	128,681.0
Хуримтлагдсан элэгдэл	(196,510.7)	(298,982.3)	(102,471.6)
Авто-тээврийн хэрэгсэл	171,927.7	232,595.1	60,667.4
Хуримтлагдсан элэгдэл	(135,183.0)	(94,605.1)	40,577.9
	483,497.5	546,341.4	32,843.9

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Машин тоног төхөөрөмж (компьютер)	(292,144.9)	(118,195.2)	173,949.7
Хуримтлагдсан элэгдэл	202,853.6	194,825.1	(8,028.5)
Тавилга, аж ахуйн эд хогшил	(97,328.6)	(76,078.1)	21,250.5
Хуримтлагдсан элэгдэл	120,300.8	159,465.4	39,164.6
Зам гүүрийн байгууламж	(89,142.8)	(56,523.4)	32,619.4
Хуримтлагдсан элэгдэл	694,317.7	693,190.3	(1,127.4)
Бусад үндсэн хөрөнгө	(124,720.8)	(162,218.6)	(37,497.8)
Хуримтлагдсан элэгдэл	83,356.4	83,356.4	-
Дуусаагүй барилга байгууламж	33,117.1	34,910.7	1,793.6
Ном			
Программ хангамж	6,900.0	6,900.0	-
Хуримтлагдсан элэгдэл	(1,635.1)	(3,047.6)	(1,412.5)
Бусад биет бус хөрөнгө	116,354.8	116,354.8	-
Дүн	4,195,950.9	4,606,940.2	410,989.3

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 285,244.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 47,910.5 мянган төгрөг, ОНХС-аас 194,949.6 мянган төгрөг, үнэ төлбөргүйгээр хүлээн авсан 141,592.8 мянган төгрөг, дахин үнэлж орлогод авсан 295,115.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, 345,523.8 мянган төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг данснаас хассан болон 48,800.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан зэргээс шалтгаалсан байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 5,650.9 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 667.1 мянган төгрөг болж, 4,983.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Хувь хүмүүст төлөх өглөг	-	150.0	150.0
Байгууллагад төлөх өглөг	5,650.9	517.1	(5,133.8)
Нийт дүн	5,650.9	667.1	(4,983.8)

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд барьцаа хөрөнгийн дансанд 390.0 мянган төгрөг, ОНХО-ын дансны үлдэгдэл 127.1 мянган төгрөг, хувь хүнд өгөх 150.0 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

ЭМТ:

- Тайлант хугацаанд үйлчлэгч А.Пүрэвсүрэнгийн 1,662.6 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлсийг нийгмийн даатгалын шимтгэл болон ХХОАТ-ын тайланд дутуу тайлагнасан нь өр төлбөр үүсгэх эрсдэлтэй байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,877,270.9 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 5,488,292.1 мянган төгрөг болж, 611,021.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,873,329.3	1,873,329.3	-
Хуримтлагдсан үр дүн	1,826,309.7	2,444,054.8	617,745.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,177,631.9	1,177,631.9	-
Дүн	4,877,270.9	5,495,016.0	617,745.1

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 617,745.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн хуримтлагдсан үр дүн өссөнөөс шалтгаалсан байна.

3.5.7 Орлогын данс

Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон сумын ЗДТГ-ын түрээсийн төлбөрийн 500.0 мянган төгрөг, сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн 69,541.4 мянган төгрөг зэрэг нийт 70,041.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

3.5.7 Зарлагын данс

Аудитын илрүүлэлт:

ИТХ:

- “Төрийн албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх” чиглэлийн хүрээнд Аймгийн ИТХ-аас 4 өдрийн сургалтыг зохион байгуулж, албан томилолтын зардлыг тооцож олгосон атал Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Б.Ариунжаргалд 236.0 мянган төгрөгийг тухайн сумын ИТХ-ын төсвөөс давхардуулан олгосон.

ЗДТГ:

- Албан томилолтын зардлын тогтоосон жишиг нормыг мөрдөөгүй буюу буудлын зардлыг аймагт 40.0 мянган төгрөгөөр тооцож нийт 146.0 мянган төгрөгийг илүү олгосон.
- Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс нийт 5,526.2 мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна.

Сум хөгжүүлэх сан:

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

- Сумын ИТХ-аас баталсан сум хөгжүүлэх сангийн тэргүүлэх чиглэлээс өөр зориулалтаар буюу сүү, сүүн бүтээгдэхүүний чиглэлээр уг сангаас 2 иргэнд нийт **10,000.0** мянган төгрөгийн зээлийг олгосон.

ЭМТ:

- Холбогдох албан тушаалтны шийдвэргүйгээр буюу анхан шатны баримтын бүрдэлгүйгээр М.Гантүшигт **233.7** мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон.
- Шатахууны зарцуулалтыг батлагдсан нормативтай тулган шалгахад авто машины 100 км-т зарцуулах шатахууны нормыг хэтрүүлэн **915.5** мянган төгрөгийн шатахууныг илүү тооцож олгосон. *Авто машины шатахууны бодит хэрэглээг тогтоогоогүй /*
- Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс нийт **1,212.4** мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна.

Соёлын төв:

- Номын санч Л.Баярцэцэгт бичиг хэргийн албан тушаал хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг уг хавсран гүйцэтгэж буй албан тушаалын цалингаас бус эрхэлж буй албан тушаалын үндсэн цалингаас тооцож **131.7** мянган төгрөг илүү тооцож олгосон.
- Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс нийт **247.5** мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв,

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн татварын болон татварын бус орлого бүрдүүлэлт:

Сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 2020 оны 12 дугаар тогтоолд зааснаар Түшиг сум нь тайлант онд 76,989.0 мянган төгрөгийн татварын орлого, 15,500.0 мянган төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 360,997.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 3.9 дахин давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №7. Төвлөрүүлэх орлого

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөг/	
			Зөрүү	Хувь
Хувь хүний орлогын албан татвар	15,000.0	9,702.1	(5,297.9)	64.7
Хөрөнгийн татвар	2,500.0	10,435.2	7,935.2	4.2дах
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	100.0	13,054.0	12,954.0	130.5

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бууны татвар	1,890.0	3,460.0	1,570.0	183.0
Малын тоо толгойн албан татвар		42,904.0	42,904.0	100.0
Газрын дуудлага худалдаа	3,440.0	40.0	(3,400.0)	2.0
Улсын тэмдэгтийн хураамж	4,500.0	4,200.8	(299.2)	94.0
Ан агнуурын нөөц ашигласны төлбөр	2,692.0	720.0	(1,972.0)	27.0
Байгалийн ургамал нөөц ашигласны төлбөр	2,920.0	1,527.6	(1,392.4)	53.0
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	1,000.0	1,200.0	200.0	120.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3,000.0	3,014.5	14.5	100.5
Ойн нөөц ашигласны төлбөр	39,947.0	262,670.0	222,723.0	6.6дах
Хүү торгуулийн орлого	10,000.0	5,029.5	(4,970.5)	50.3
Нэр зааж ангилагдаагүй орлого	3,000.0	1,092.0	(1,908.0)	37.0
Түрээсийн орлого	2,500.0	1,947.3	(552.7)	77.9
Нийт дүн	92,489.0	360,997.0	268,508.0	3.9дах

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелсэн нь ойн нөөц ашигласны төлбөр 222,723.0 мянган төгрөгөөр, малын тоо толгойн албан татвар 42,904.0 мянган төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 12,954.0 мянган төгрөгөөр, хөрөнгийн татвар 7,935.2 мянган төгрөгөөр, бууны албан татвар 1,570.0 мянган төгрөгөөр тус тус давсан нь голлон нөлөөлсөн бол хүү торгуулийн орлого 4,970.5 мянган төгрөгөөр, газрын дуудлага худалдаа 3,400.0 мянган төгрөгөөр, ан агнуурын нөөц ашигласны төлбөр 1,972.0 мянган төгрөгөөр, нэр зааж ангилагдаагүй орлого 1,908.0 мянган төгрөгөөр, байгалийн ургамал, нөөц ашигласны төлбөр 1,392.4 мянган төгрөгөөр тус тус тасарснаас шалтгаалсан байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний төлөвлөгөөнөөс давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давсан орлого

- Ойн нөөц ашигласны төлбөр 222,723.0 мянган төгрөгөөр буюу 6.6 дахин давж биелсэн нь 2021 онд орлогын төлөвлөгөө батлагдсаны дараа аймгийн ИТХ-ын 18 дугаар тогтоолоор модны хуваарьт өөрчлөлт оруулсантай холбоотойгоор 8, 12 дугаар сард Улаанбаатар төмөр замд 5350 метр куб, Шинэбадрах ХХК-нд 470 метр куб, Мойлт нуга ХХК-нд 300 метр куб модны хуваарийг тус тус нэмж баталсан болон тухайн жилийн ойн нөөц ашигласны төлбөрийн хэмжээ шинэчлэгдсэнтэй холбоотой байна.
- Малын тоо толгойн албан татвар 42,904.0 мянган төгрөгөөр давж биелсэн нь Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдөгдөж эхэлснээс төлөвлөгөөнд тусгаагүйгээс шалтгаалсан байна.
- Орлогын төлөвлөгөөг үндэслэлгүй төлөвлөснөөс хөрөнгийн татвар буюу хадгаламжийн хүүгийн орлого 7,935.2 мянган төгрөгөөр, бууны албан татвар 1,570.0 мянган төгрөгөөр давж биелсэн байна,
- Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 12,954.0 мянган төгрөгөөр давсан нь өвөлжөө, хашаа байшин ихээхэн зарагдсанаас шалтгаалсан байна.

Тасарсан орлого

- Газрын дуудлага худалдааны төлөвлөгөө 3,400.0 мянган төгрөгөөр тасарсан нь тайлант оны эцэст газрын дуудлага худалдаа зохион байгуулагдах байсан боловч газар төлөвлөлтийн төлөвлөгөөнд тусгагдсан кадастрын зураг хийгдээгүйгээс шалтгаалсан байна,
- Ан агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлого 1,972.0 мянган төгрөгөөр тасарсан нь Сумын ИТХ-ын 2021 оны 27 дугаар тогтоолоор 2021, 2022 онд тухайн суманд загас агнахыг хориглосонтой холбоотой байна,
- Байгалийн ургамал нөөц ашигласны төлбөрийн орлого 1,392.4 мянган төгрөгөөр тасарсан нь тухайн жилд самар ургаагүйгээс шалтгаалсан байна,
- Хүү торгуулийн орлого 4,970.5 мянган төгрөгөөр тасарсан нь бэлэн бус торгуулийн орлого суманд төвлөрөөгүйтэй холбоотой байна,
- Төлөвлөгөөг үндэслэлгүй төлөвлөснөөс нэр зааж ангилагдаагүй орлого 1,908.0 мянган төгрөгөөр тасарсан байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,507,048.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,507,048.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар тогтоолоор төсвийн орлогыг 92,989.0 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 609,692.6 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 89,634.8 мянган төгрөг, ОНХС-ын урьд оны үлдэгдлээс 151,869.3 мянган төгрөг, ТЗШ-ийн байгууллагын санхүүжилтийг 1,251,714.7 мянган төгрөг, ЭМДС-ийн санхүүжилтийг 20,263.9 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлт 74,200.0 мянган төгрөг зэрэг нийт 2,290,364.3 төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 16 дугаар тогтоолоор аймгийн төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2021 оны 25 дугаар тогтоолоор дараах өөрчлөлтийг оруулан төсвийн орлого, зарлагыг нэмэгдүүлж **2,445,947.0** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- ТЗШ-ийн байгууллагын санхүүжилтийг 53,582.7 мянган төгрөгөөр, аймгаас олгох санхүүгийн дэмжлэгийг 32,000.0 мянган төгрөгөөр, сумын урьд оны үлдэгдлээс 70,000.0 мянган төгрөгөөр санхүүжилтийг тус тус нэмэгдүүлж тодотгосон,
- Ковид-19 цар тахал болон малын шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан ЗДНХ-ийн зардлыг 43,525.0 мянган төгрөгөөр, ЗДТГ-ын цалин, НДШ-ийн зардлыг 24,475.0 мянган төгрөгөөр, **урсгал засварын зардлыг 20,000.0 мянган төгрөгөөр**, ИТХ-ын багаж, техник хэрэгсэл авах зардалд 4,000.0 мянган төгрөг, **ГХУС зардалд 5,000.0 мянган төгрөгөөр** тус тус нэмэгдүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 2,445,947.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас ТЗШ-ийн байгууллагуудын төсөвт зохицуулалт хийгдэж тус сумын ТЗШ-ийн байгууллагуудад нийт 22,602.7 мянган төгрөгийг нэмж, 1,327,900.1 мянган төгрөг болгон өөрчилснөөс шалтгаалж **2,468,549.7** мянган төгрөг болж өөрчлөгдсөн байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрт зориулан 2,468,549.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,153,505.6 мянган төгрөгийг урсгал зардалд, 241,504.1 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 73,540.0 мянган төгрөгийг СХС-ийн эргэн төлөгдөх зээлийн зардалд зарцуулахаар төлөвлөжээ.

Нийт зардлын 641,692.6 мянган төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс, 92,489.0 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, 500.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 70,000.0 мянган төгрөгийг оны эхний үлдэгдлээс, 74,200.0 мянган төгрөгийг СХС-ийн эх үүсвэрээс, 89,634.8 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээс, 151,869.3 мянган төгрөгийг ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс, 20,263.9 мянган төгрөгийг ЭМД-ын сангаас, 1,327,900.1 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр аймгаас авах санхүүгийн дэмжлэг 641,692.6 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 1,327,900.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 92,489.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 500.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 2,054.3 мянган төгрөг, ОНХС-аас 89,634.8 мянган төгрөг, ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс 151,869.3 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлт 69,541.4 мянган төгрөг, ЭМД-ын сангаас 9,279.7 мянган төгрөг зэрэг нийт **2,384,961.2** мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,302,878.8 мянган төгрөг буюу 93.2 хувьтай тайлагнагдсан нь ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх 20,000.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, ЭМД Сангийн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь олгосон, ТЗШ-ийн санхүүжилтийн хэмнэгдсэн зардлыг татан төвлөрүүлсэн болон орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон зэргээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал болон НДШ-ийн зардал 59,155.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 17,189.6 мянган төгрөг, бараа материалын зардал 1,051.3 мянган төгрөг, нормативт зардал 11,907.2 мянган төгрөг, урсгал засварын зардал 2,290.9 мянган төгрөг, албан томилолтын зардал 171.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 2,061.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 14,091.5 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 5,455.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын төсвийн хөрөнгө оруулалт батлагдаагүй бөгөөд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 8 төсөл, арга хэмжээнд 241,504.1 төгрөгийн санхүүжилт

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

олгохоор батлагдсанаас гүйцэтгэлээр 205,748.2 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, 39,560.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчдаас 23,606.15 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 65,520.7 мянган төгрөг, иргэн хуулийн этгээдээс ковид-19 цар тахалтай тэмцэхэд өгсөн хандив 14,300.0 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого 46,367.63 мянган төгрөг зэрэг нийт 149,794.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Сумын ЗДТГ-т Статистикийн хэлтсээс хагас жилийн малын тооллогын зардалд 758.3 мянган төгрөг, МЭГ-аас шүлхий өвчний шатахууны зардалд 1,000.0 мянган төгрөг, ХААГ-аас махны үзэсгэлэн худалдаанд оролцох шатахууны зардалд 746.0 мянган төгрөг, аймгийн ЗДТГ-аас аймагт зохион байгуулагдах үзэсгэлэн худалдаанд оролцох шатахууны зардалд 100.1 мянган төгрөг, сумын ИТХ-д аймгийн ИТХ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 300.0 мянган төгрөг, ЭМТ-д аймгийн ЭМГ-аас цар тахлын үед ажилласан албан хаагчдын илүү цагийн хөлс, урамшуулалд 19,892.8 мянган төгрөг, БСУГ-аас ариутгалын бодисын зардалд ЕБС-д 595.0 мянган төгрөг, цэцэрлэгт 214.0 мянган төгрөг зэрэг нийт 23,606.2 мянган төгрөгийг тус тус шилжүүлсэн,
- Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлогоор буюу Шаамар сумын ЭМТ-өөс ковидын тасагт ажилласан ажилчны урамшуулалд 1,870.4 мянган төгрөг, ЭМДЕГ-аас ковидын өрхийн багц, вакцины урамшуулалд 37,144.8 мянган төгрөг, эргэлтийн эмийн сангийн хөнгөлөлттэй эмийн орлого 7,352.4 мянган төгрөг зэрэг нийт 46,367.63 мянган төгрөгийг тус тус шилжүүлсэн,
- Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор буюу сумын соёлын төвийн байрны түрээсийн төлбөрт 420.0 мянган төгрөг, ЗДТГ-ын цахим тендерийн хураамжийн орлого 560.0 мянган төгрөг, ЕБС-ийн түрээсийн номын 1,043.1 мянган төгрөгийн, ЭМТ-ийн эргэлтийн эмийн сангийн орлогоос 63,497.6 мянган төгрөг зэрэг нийт 65,520.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн,
- Хандиваар ЭМТ-д Сэлэнгийн тариалан ХХК-аас 5,000.0 мянган төгрөг, иргэдээс 4,300.0 мянган төгрөг, ЗДТГ-т Илч хужирт ХХК-иас 1,000.0 мянган төгрөг, Гацуурт ХХК-иас 1,000.0 мянган төгрөг, Түшиг индустрал ХХК-иас 3,000.0 мянган төгрөг зэрэг нийт 14,300.0 мянган төгрөгийг хандивын орлогоор бүртгэсэн,
- Үүнээс цалин хөлсөнд 12,651.5 мянган төгрөг, НДШ-д 1,715.3 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 5,317.3 мянган төгрөг, нормативт зардалд 89,296.5 мянган төгрөг, урсгал засварын зардалд 350.0 мянган төгрөг, албан томилолтын зардалд 180.0 мянган төгрөг, бусдаар

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

гүйцэтгүүлэх зардалд 1,533.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 14,300.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, урамшуулалд 19,600.0 мянган төгрөг зэрэг нийт 144,943.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 4,850.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Санхүүгийн тайланд СХС-гаас олгосон зээлийн авлага 172,391.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсанаас 2011-2018 онд олгосон хугацаа хэтэрсэн 30 иргэний үндсэн зээлийн 79,865.9 мянган төгрөг, хүү, алдангийн авлагын 3,247.0 мянган төгрөг буюу нийт 83,112.9 мянган төгрөгийн зээлийн авлагыг барагдуулахаар холбогдох шатны шүүхэд хандаж, шийдвэрлүүлэх арга хэмжээ аваагүй байгаа нь найдваргүй авлага үүсэх, СХС-ийн эргэлтийг удаашруулах, эх үүсвэр дутагдах эрсдэлийг үүсгэж байна. Иймд цаашид хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах талаар бодитой арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай байна.

3.7.2 Сумын ЗДТГ, ЭМТ, Соёлын төв зэрэг байгууллагуудын санхүүгийн тайлангийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд бүртгэлтэй хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү нь үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд бүрэн тусгагдаагүй буюу аль хөрөнгөд хамаарах нь тодорхой бус байгаа тул үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд хөрөнгө тус бүрд хамаарах дахин үнэлгээний нэмэгдлийг тусган оруулж, НББОУС 16 “Үндсэн хөрөнгө” стандартыг баримтлан ажиллах.

3.7.3 Сумын ЗДТГ, ЭМТ, Соёлын төв зэрэг байгууллагуудын татварын цахим системийн татварын үлдэгдлийн тооцоололд цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар болон суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар нь санхүүгийн тайлангаас зөрүүтэй тайлагнагдсан байгаа нь татварын авлага, өр төлбөр үүсэх эрсдэлийг үүсгэж байна. Иймд 2022 оны эхний хагас жилд багтаан тооцоо нийлж, татварын үлдэгдлийг тулган баталгаажуулах шаардлагатай байна.

3.7.4 Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон төрийн сангийн мэргэжилтэн Л.Сарангэрэлд нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгохдоо анхан шатны баримтад тулгуурлан тооцоо бодож олголгүйгээр, өөрийн гаргасан өргөдлийг үндэслэн *Аймгийн СТСХэлтсээс хянаж ирүүлсэн Номгоны САА-д 1985-1992 онд ажиллаж байсан 6 жилийн хугацааг төрийн албанд ажилласан хугацаанд оруулан тооцсон/23,704.5* мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 3.1-д “Төрийн албан хаагчийн төрийн албанд ажилласан хугацаанд дараах хугацааг оруулан тооцно” 3.1.4: “Улсын төсөвт үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал, захиргааны ажилтан, бусад ажилтнаар 1996 оны 8 дугаар сарын 1-нээс 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдөр хүртэл ажилласан хугацаа” гэж зохицуулсан байдаг. Сангийн аж ахуйд ажиллаж байсан хугацааг төрийн албанд ажилласан хугацаанд оруулж тооцсон нь дээрх тогтоолын заалтыг зөрчсөн байх эрсдэлийг үүсгэж байгаа учир төрийн албанд ажилласан хугацааг үнэн зөв тодорхойлж, тэтгэмж олгох нь зүйтэй гэж үзэж байна.

3.7.5 Тайлант онд төлбөрийн баримтын цахим системд илүү шивэгдсэн ЗДТГ-ын 7,676.9 мянган төгрөг, ЭМТ-ийн 8,036.9 мянган төгрөг, Соёлын төвийн 541.1 мянган төгрөг зэрэг нийт **16,254.9** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалт байгаа нь анхан шатны баримтгүй болон баримтын бүрдэлгүй орлого, зарлагын гүйлгээг хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгах эрсдэлийг үүсгэж байна. Иймд төлбөрийн баримтын цахим системийг үнэн зөв хөтлөх, алдаатай эсвэл буруу шивэгдсэн баримтуудыг тухай бүр залруулж байх шаардлагатай байна.

3.7.6 Сэлэнгэ аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 177 дугаар шийдвэрээр хууль бусаар ажлаас халагдсан нь тогтоогдсон Л.Сарангэрэлд 2016 оны 8-12 дугаар сард ажилгүй байсан хугацааны 4,191.8 мянган төгрөгийн цалин хөлс, 461.1 мянган төгрөгийн НДШ-ийн зардал зэрэг нийт **4,652.9** мянган төгрөгийг байгууллагаас барагдуулсан байна. Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2022 онд хийж гүйцэтгэсэн хяналт шалгалтаар ЗДТГ-ын хууль бус шийдвэрийн улмаас мэргэжилтэн Л.Сарангэрэлд 4,191.9 мянган төгрөгийн цалин олгож төсөвт хохирол учруулсныг сумын ЗДТГ-ын дарга Б.Уранчимэгээр төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон байна. Иймд хохирлыг нөхөн төлүүлж, байгууллагыг хохиролгүй болгох арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй юм.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1. Түшиг сумын ТТЗ-ийн мэдээлбэл зохих 155 мэдээллээс 129 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 26 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

2. “Мандал зэлтэр тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд цахим хаяг нээлгээгүй байна.

3. Сумын ЗДТГ нь мэдээлбэл зохих 149 мэдээллээс 25 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

4. ИТХ нь мэдээлбэл зохих 149 мэдээллээс 20 мэдээллийг хугацаа хоцроож, 4 мэдээллийг мэдээлээгүй.

5. ЭМТ нь мэдээлбэл зохих 149 мэдээллээс 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

6. Соёлын төв мэдээлбэл зохих 149 мэдээллээс 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд:

1. “Мандах зэлтэр тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь орлого, зардлын төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь “*Байгууллагын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй*” гэсэн заалтыг зөрчиж байна.

2. Түшиг сумын ТТЗ-ийн тайлант оны үйл ажиллагаанд 2,468,549.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 2,302,878.8 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 6.7 хувиар хэмнэсэн.

Харьяа төсвийн байгууллагуудын төсвийн хэмнэлтийг тодруулбал:

- ИТХ-ын тайлант оны үйл ажиллагаанд 59,229.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 57,570.8 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 2.8 хувиар,
- Соёлын төвийн 2021 оны үйл ажиллагаанд 103,878.1 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 100,788.9 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 3.0 хувиар тус тус хэмнэсэн байна.

Эдгээр нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “*....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасантай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 1,516.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 15,913.0 мянган төгрөгийн 5 албан шаардлага бүрэн биелэлттэй, 5 зөвлөмжийн хэрэгжилт 80.0 хувьтай байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	2	1,516.5	2	1,516.5	100.0

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Албан шаардлага	4	15,913.0	4	15,913.0	100.0
Зөвлөмж	5	13,219.4	4	13,219.4	80.0
Нийт дүн	11	30,648.9	10	30,648.9	90.9

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлын улмаас ОНХС, ОНХО-ын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, худалдан авах ажиллагаа, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг шалган баталгаажуулах боломжгүй байсан учир сэдэвчилсэн гүйцэтгэлийн аудитуудаар гүнзгийрүүлэн шалгах нь зүйтэй юм.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 2 байгууллагын санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргаж, 4 байгууллага, 2 тусгай сангийн тайлан түүвэрт хамрагдсан байна.

Түшиг сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 298,472.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 142,158.2 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 747.4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоон, 12,537.7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэн, 143,029.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 8 зөвлөмжийг хүргүүллээ.

Аудитад хамрагдсан ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

ТТЗ-ийн түвшний аудитаар нийт 284,200.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 141,308.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 747.4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 12,537.7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэн, 129,606.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 7 зөвлөмжийг хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа:

Аудитын явцад дараах алдааг залруулав. Үүнд:

- Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд ЗДТГ нь 10,000.0 мянган төгрөг, соёлын төв нь 45,182.3 мянган төгрөг, эрүүл мэндийн төв нь 34,707.2 мянган

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

төгрөгийн аймгийн хөрөнгө оруулалт, сумын ОНХС-аар хийгдсэн их засварын ажлыг барилгын өртөгт шингээж, капиталжуулаагүй,

- Үндсэн хөрөнгөд ЗДТГ нь 274.7 мянган төгрөг, ЭМТ нь 37,630.5 мянган төгрөг, Соёлын төв нь 3,323.6 мянган төгрөгийн элэгдэл байгуулалгүй, санхүүгийн үр дүнг дутуу илэрхийлсэн,
- ЗДТГ нь албан хаагчийн цалингаас суутгасан СХС-ийн 150.0 мянган төгрөгийн өглөгийг тус тус санхүүгийн тайланд өр төлбөрөөр тусгалгүй орхигдуулсан,
- ЭМТ нь ЭМД сангаас авах хөнгөлөлттэй эмийн болон вакцины урамшууллын зэрэг 6,744.7 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгалгүй орхигдуулсан,
- ЭМТ нь 3,295.2 мянган төгрөгийн эм, боох материалыг нөөцийн бараа материалын дансанд буруу бүртгэснийг тус тус залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Иргэдийн төлөөлөгчдийн хурал:

4.2.1 Аймгийн ИТХ-аас “Төрийн албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх” чиглэлийн хүрээнд 4 өдрийн сургалтыг зохион байгуулж, албан томилолтын зардлыг тооцож олгосон атал ИТХ-ын нарийн бичгийн дарга Б.Ариунжаргалд **236.0** мянган төгрөгийг сумын ИТХ-ын төсвөөс давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байгаа бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон албан томилолтын зардлыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

Засаг даргын Тамгын газар:

4.2.2 Албан томилолтын зардлын тогтоосон жишиг нормыг мөрдөөгүй буюу буудлын зардлыг аймагт 40.0 мянган төгрөгөөр тооцож 4 албан хаагчид нийт **146.0** мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Сангийн сайдын “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2018 оны 301 дүгээр тушаалын 1 дэх “Албан хаагчдын албан томилолтын ... байрны зардлыг аймгийн төвд 36,000 төгрөг, ...” гэсэн заалтыг тус тус зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон албан томилолтын зардлыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

Эрүүл мэндийн төв:

4.2.3 Холбогдох албан тушаалтны шийдвэргүйгээр буюу анхан шатны баримтын бүрдэлгүйгээр М.Гантүшигт **233.7** мянган төгрөгийн үр чадварын нэмэгдэл олгосон

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

Соёлын төв:

4.2.4 Номын санч Л.Баярцэцэгт бичиг хэргийн албан тушаал хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг уг хавсран гүйцэтгэж буй албан тушаалын цалингаас бус эрхэлж буй албан тушаалын үндсэн цалингаас тооцож **131.7** мянган төгрөг илүү тооцож олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*”, Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “*Төрийн үйлчилгээний бусад байгууллагын болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл*” ... ТҮ-5–архив, бичиг хэргийн эрхлэгч” гэсэн заалтуудтай нийцэхгүй ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.3 Албан шаардлага

Иргэдийн Төлөөлөгчдийн хурал:

4.3.1 Аж ахуйн материал дансанд **1,115.0** мянган төгрөгийн материал бүртгэлтэй боловч жилийн эцсийн тооллогоор баталгаажуулаагүй, бодитой оршин байхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “*Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:*”, 20.2.6-д “*Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, ... үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*” гэсэн заалттай нийцэхгүй байгаа бөгөөд “Оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 2022 оны эхний хагас жилд багтаан тооллого хийж, санхүүгийн тайланд үнэн зөв тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

4.3.2 Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас НДШ-ийн **108.3** мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтыг тус тус зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулж, гүйцэтгэж байх албан шаардлага хүргүүлэх.

Засаг даргын Тамгын газар:

4.3.3 Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас тайлант онд НДШ-ийн **398.9** мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтыг тус тус зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулж, гүйцэтгэж байх албан шаардлага хүргүүлэх.

Эрүүл мэндийн төв:

4.3.4 Шатахууны зарцуулалтыг батлагдсан нормативтай тулган шалгахад авто машины 100 км-т зарцуулах шатахууны нормыг хэтрүүлэн **915.5** мянган төгрөгийг илүү тооцож олгон бүртгэл тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2-т “*Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 01 дүгээр хавсралт “Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ыг тус тус зөрсөн*” бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид тогтоосон жишиг нормын мөрдөж, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулж, гүйцэтгэх, шатахууны зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлэх.

Сум хөгжүүлэх сан:

4.3.5 Сумын ИТХ-аас баталсан тэргүүлэх чиглэлээс өөр зориулалтаар буюу сүү, сүүн бүтээгдэхүүний чиглэлээр 2 иргэнд нийт **10,000.0** мянган төгрөгийн зээлийг сум хөгжүүлэх сангаас зориулалт бусаар олгосон. Энэ нь Сумын ИТХ-ын 2021 оны 20 дугаар тогтоолоор баталсан “*Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зориггоор сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн тэргүүлэх чиглэлийг эрчимжсэн мал аж ахуйг дэмжих болон төмс хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих*” гэсэн заалттай нийцэхгүй байгаа бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэх.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.4.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой:

Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс ЗДТГ нь 5,526.2 мянган төгрөг, Соёлын төв нь 247.5 мянган төгрөг, ЭМТ нь 1,212.4 мянган төгрөг зэрэг нийт **6,986.1** мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна.

Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална", 5.1.2 дахь "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул зардлыг бодит тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж байх.

Илрүүлэлт: Сумын Засаг даргын захирамж, шийдвэр гараагүй буюу зарцуулах эрх үүсээгүй байхад ЗДНХ-өөс **17,098.1** мянган төгрөгийг зарцуулж, бүртгэл тайланд тусгасан байна.

Өгсөн зөвлөмж: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 13.7 дэх "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчиж байгаа тул цаашид анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл, тайланд тусгаж байх.

4.4.2 Бараа материалын данстай холбоотой:

Илрүүлэлт: ЭМТ нь албан хаагчдад тавьж олгосон нормын хувцас хэрэглэлийг тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүйгээс нормын хувцасны дансны үлдэгдэл **3,624.6** мянган төгрөгөөр нэмэгдэж, санхүүгийн байдлын тайлангийн эргэлтийн хөрөнгийн дүнг хий өсгөж, бодитоор илэрхийлэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-д "...байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь ...хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэж заасныг зөрчсөн бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна. Иймд нормын хувцасны хангалтыг тухай бүр зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнан, ашиглалтын хугацаанд хяналт тавих, өмнөх онуудад албан хаагчдад олгосон нормын хувцас хэрэглэлийг зардлаар тайлагнаж, материалын үлдэгдлийг үнэн зөв илэрхийлэх.

4.4.3 Авлага, өглөгийн данстай холбоотой:

Илрүүлэлт: ЭМТ нь жилийн эцэст НДШ болон ХХОАТ-ыг холбогдох байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулсан хэдий ч үйлчлэгч А.Пүрэвсүрэнгийн **1,662.6** мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлсийг НДШ-ийн тайланд дутуу тайлагнаснаас НДШ болон ХХОАТ-ын өр төлбөр үүсэж болзошгүй байна.

Өгсөн зөвлөмж: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчиж байгаа бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна. Иймд НДШ

болон татварын тайланд нөхөн тайлагнаж, авлага, өглөгийг бодитоор тайланд тусгаж байх.

4.4.4 Нэмэгдэл цалин хөлстэй холбоотой:

Илрүүлэлт: Сумын ЭМГ, ЗДТГ, ИТХ, Соёлын төв зэрэг байгууллагууд нь албан хаагчдын илүү цагийн нэмэгдэл хөлсний тооцоог “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-аар баталгаажуулж, олгоогүй байна.

Өгсөн зөвлөмж: Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 3.4-ыг зөрчиж байгаа бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул цаашид илүү цагийн нэмэгдлийг батлагдсан маягаар баталгаажуулсны үндсэн дээр олгож байх.

4.4.5 Төлбөрийн цахим баримттай холбоотой:

Илрүүлэлт: Тайлант онд ЗДТГ нь 45,507.8 мянган төгрөг, ЭМТ нь 38,265.3 мянган төгрөг, Соёлын төв нь 16,462.4 мянган төгрөг зэрэг нийт **100,235.5** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

4.4.6 Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгатай холбоотой:

Илрүүлэлт: Сумын ИТХ, ЗДТГ, ЭМТ болон соёлын төв зэрэг байгууллагууд нь санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна, 8.1.5: “санхүүгийн тайлангийн тодруулга.” гэсэн заалтыг зөрчиж байгаа тул цаашид санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийж байх.

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/ Мянган тегрөгөөр/

Д/Д	Байгууллагын нэр	Аудитын код	Зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс				Зөвлөмж				
				Тоо	Дүн	Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох	Тоо	Дүн
						Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1			ИТХ нь албан томилолтын зардлыг давхардуулан олгосон.	1	236.0			1	236.0					
2			ЭМТ нь холбогдох албан тушаалтны шийдвэргүйгээр М.Гантушигт ур чадварын нэмэгдэл олгосон.	1	233.7			1	233.7					
3			ЗДТГ нь албан томилолтын зардлыг илүү тооцож олгосон.	1	146.0			1	146.0					
4			Соёлын төв нь Л.Баярцэцэгт хавсран ажилласны нэмэгдэл цалинг илүү тооцож олгосон.	1	131.7			1	131.7					
5	ТТЗ	СЭА-2022/13-НА-СТА-ТТЗ	ИТХ нь аж ахуйн материал дансанд бүртгэлтэй боловч жилийн эцсийн тооллогоор баталгаажуулаагүй, уг хөрөнгө бодитой оршин байхгүй байна.	1	1,115.0					1	1,115.0			
6			Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас ИТХ, ЗДТГ нь НДШ-ийн авлага үүсгэсэн.	1	507.2					1	507.2			
7			ЭМТ нь авто машины шатахууны нормыг хэтрүүлэн илүү тооцож олгосон.	1	915.5					1	915.5			
8			Сумын ИТХ-аас баталсан тэргүүлэх чиглэлээс өөр зориулалтаар сум хөгжүүлэх сангаас зээл олгосон	1	10,000.0					1	10,000.0			
9			-ЗДТГ, ЭМТ, соёлын төв зэрэг байгууллагууд бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан	1	100,235.5							1	100,235.5	

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

19		ЭМТ нь эм, боох материалыг нөөцийн бараа материалын дансанд ангилал буруу бүртгэсэн.	1	3,295.2	1	3,295.2								
20		ЭМТ нь ЭМД сангаас авах санхүүжилтийн авлагыг санхүүгийн тайланд дутуу илэрхийлсэн.	1	6,744.7	1	6,744.7								
ДҮН			20	284,200.2	5	141,308.2	4	747.4	4	12,537.7	7	129,606.9		
Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн аудит														
1	СЭА-2022/13-НА-СТА-ТТЗ	ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг зөрчиж батлагдсан төсвийг 10-аас доош хувиар хэмнээгүй.	1								1			
2		Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон буюу огт мэдээлээгүй.	1								1			
3		"Мандах зэлтэр тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ нь орлого, зардлын төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй байна.	1									1		
ДҮН			3								3			
НИЙТ ДҮН			23	284,200.2	5	141,308.2	4	747.4	4	12,537.7	7	129,606.9		